



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Самбо бөхийн дүүргийн аварга
шалгаруулах тэмцээн зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Самбо бөхийн өсвөр үеийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 09-нөөс 10-ны өдрүүдэд Амгалан цогцолбор сургууль дээр зохион байгуулсугай.


2. Тэмцээний зардалд 1,624,000 (Нэг сая зургаан зуун хорин дөрвөн мянга)-н төгрөгийг Спортын тэмцээн, уралдааны зардлаас гаргахыг Нягтлан бодогч (П.Бат-Оюун)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Спортын хэлтсийн дарга (Ю.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОТГОНСҮРЭН



Баянзурх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/10 тушаалын хавсралт

Улаанбаатар хот

ТӨСӨВ

2024 оны 03 дугаар сарын 01

Чөлөөт бөхийн өсвөр үеийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээн

№	Спортын тэмцээний төрөл	Хугацаа	Зардлын нэр төрөл	Жин, зай, насны ангилал тус бүрээр		Багийн дүн			Нийт	
				Тоо ширхэг	Нэгж үнэ	Тоо ширхэг	Нэгж үнэ	Тоо	Үнэ	
1	Самбо бөхийн өсвөр үеийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээн	3 сард	Мөнгөн шагнал							
			Өргөмжлөл	64	8,000	3	8,000	67	536,000	
			Шүүгч	8	80,000	-	-	8	640,000	
			Техник, үйлчилгээ	2	50,000			2	100,000	
				Нийт 1,624,000						